



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/612

Мөрөн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 48 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 47 дугаар зүйлийн 47.1.6, 47.2, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн суудалтай хичээлийн барилга бүрэн дуусгавар болоогүй байхад хүлээж авсан, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг зөрчиж шийдвэр гаргасан байх тул “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс томилох тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/679 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн УКД-2020/97 дугаартай дүгнэлт хүчингүй болсныг дурдсугай.

3.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6712011417